



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв/ 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код:

**ХӨА-2023/181/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум

2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317

Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99900662

Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: С.Гансүх

Утас: 95908400

Цахим хаяг: [gansukhsa@audit.gov.mn](mailto:gansukhsa@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	3
Аудитын гол асуудал.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ /ТӨГРӨГӨӨР/. 5	
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	7
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	10
4.1 Ерөнхий зүйл .....	10
4.2 Материаллаг байдал .....	10
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
4.5.1 Завсрын аудитын талаар .....	11
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	11
5.1 Төлбөрийн акт .....	11
Аудитаар төлбөрийн акт өгөөгүй.....	11
5.2 Албан шаардлага.....	11
5.3 Зөвлөмж .....	11

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв/ 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.15 № 01/65  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,  
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Т.РАДНААБҮД ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн халамжийн сангийн /Улсын төсөв/ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн халамжийн сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Улсын төсвөөс санхүүждэг Халамжийн үйлчилгээг цахим программд шилжүүлсэнтэй холбоотой орон нутагт 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөр ажил гүйлгээг тасалбар болгосон тул санхүүгийн тайлан нь 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хоорондох ажил гүйлгээг хамарсан байна

### Аудитын гол асуудал

Халамжийн сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт санхүүгийн тайлангийн дараах үйл явдал болох өмнөх онд хамаарах халамжийн өглөгийн бүртгэл, тайлагналын талаар дурдаагүй байна. Энэ нь халамжийн өглөгийн бүртгэлийг УСНББОУС-ын дагуу аккруэл сууриар бүртгэж, тайлагнах асуудалд эрсдэл учруулж байна.

### Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн төсвийн шууд захирагч Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргаар гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг тайлагнасан боловч үнэлгээг хараахан гаргаагүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж,

хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ЛӨГРӨГӨӨР/

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ [2]+[3]	0	0
	АВЛАГА [7]+[10]	0	0
33	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН [1]+[6]	0	0
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	0	0
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН [13]+[14]	0	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0	0
41	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0	0
41	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН [27]+[28]	0	0
510301	Өмнөх үеийн үр дүн	274,009.54	0
5103010002	Өмнөх үеийн үр дүн орон нутаг	0	0
510302	Тайлант үеийн үр дүн	-274,009.54	0
5103020002	Тайлант үеийн үр дүн орон нутаг	0	0
0	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН [30]+[31]+[32]+[33]	0	0
0	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН [29]+[34]	0	0

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөр	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1303	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО [2]+[3]	8,864,841,000.00	183,944,000.00
130301	Улсын төсвийн санхүүжилтийн орлого	8,864,841,000.00	183,944,000.00
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого	0	0
14	Бараа, үйлчилгээний орлого [5]+[6]+[7]+[8]	6,159.10	0
1401011	Улсын төсвийн хүүгийн орлого	6,159.10	0
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН [1]+[4]	8,864,847,159.10	183,944,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ [11]+[12]+[13]+[14]	0	0
2603	Төсөвт төвлөрүүлэх [16]+[17]	8,358,618.64	1,318,660.00
260301	Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв	8,358,618.64	1,318,660.00
260302	Төсөвт төвлөрүүлэх орон нутгийн төсөв	0	0
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ [19]-с [40]-р мөр	8,853,110,550.00	182,625,340.00
2701010101	Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт	2,094,260,840.00	0
2701010102	Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт	2,734,387,560.00	0
2701010103	Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	1,479,035,810.00	0
2701010900	Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	808,908,370.00	98,753,000.00
2701021505	Бусад хөнгөлөлт, тэтгэмжийн зардал	0	0
2701010105	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	316,951,370.00	18,928,340.00
2701010106	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	1,394,944,000.00	64,944,000.00
27020102	Ахмад дайчид алдар цолтон ахмад настанд олгох тэтгэмж хөнгөлөлт	280,000.00	0
2701010108	Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал	24,342,600.00	0
2702026000	Цаатан иргэдийн мөнгөн тэтгэмж	0	0
	Банкны шимтгэл	3,652,000.00	0
	Банкны шимтгэл УТ	3,652,000.00	0

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв/ 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2702010311	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн банкны шимтгэл	3,652,000.00	0
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	8,865,121,168.64	183,944,000.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-274,009.54	0

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1303	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,864,841,000.00	183,944,000.00
130301	Улсын төсвийн санхүүжилтийн орлого	8,864,841,000.00	183,944,000.00
130302	Орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого	0	0
1401	Бараа, үйлчилгээний орлого	1,915,159.10	0
1401011	Улсын төсвийн хүүгийн орлого	6,159.10	0
1401013	Улсын төсвийн буцаасан орлого	1,909,000.00	0
1401023	Орон нутгийн төсвийн буцаасан орлого	0	0
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ТӨВ	8,866,756,159.10	183,944,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0	0
2701+2702	НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ	8,855,019,550.00	182,625,340.00
2701021100	Халамжийн тэтгэврийн сангийн зарцуулалт	2,094,260,840.00	0
2701021200	Халамжийн тэтгэмжийн сангийн зарцуулалт	2,734,556,560.00	0
2701010103	Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн зарцуулалт	1,479,035,810.00	0
2701021500	Ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	809,220,370.00	98,753,000.00
2701021604	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	317,491,370.00	18,928,340.00
2701024000	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	1,395,832,000.00	64,944,000.00
27020102	Ахмад дайчид алдар цолтон ахмад настанд олгох тэтгэмж хөнгөлөлт	280,000.00	0
2702020308	Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулал	24,342,600.00	0
	Банкны шимтгэл	3,652,000.00	0
	Банкны шимтгэл УТ	3,652,000.00	0
2702010311	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн банкны шимтгэл	3,652,000.00	0
2603	Төсөвт төвлөрүүлэх	8,358,618.64	1,318,660.00
260301	Төсөвт төвлөрүүлэх улсын төсөв	8,358,618.64	1,318,660.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН]	8,867,030,168.64	183,944,000.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-274,009.54	0
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0	0
	Мөнгө, түүнтэй өдилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
	Мөнгө, түүнтэй өдилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Хуримтлагдсан	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2021 оны 01 сарын 1-ээрх үлдэгдэл</b>	0	274,009.54	274,009.54
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0
3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	0	274,009.54	274,009.54
4	Тайлант үеийн үр дүн	0	-274,009.54	-274,009.54
5	<b>2021 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл</b>	0	0	0
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0
7	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	0	0	0
8	Тайлант үеийн үр дүн	0	0	0
9	<b>2022 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл</b>	0	0	0

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

	Сангийн орлого	Төлөвлөгөө	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0	0	0
2	Сангийн үйл ажиллагааны зардал	183,944,000.00	182,625,340.00	1,318,660.00	99.3
3	Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлтийн зардал	100,000,000.00	98,753,000.00	1,247,000.00	98.7
4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	19,000,000.00	18,928,340.00	71,660.00	99.6
5	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	64,944,000.00	64,944,000.00	0	100.0
6	УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТ	183,944,000.00	182,625,340.00	1,318,660.00	99.3
7	МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	0	0	0	0

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

*Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Эрхэм зорилго: “Төрөөс баримталж буй нийгмийн халамжийн бодлого зохицуулалтыг нягт уялдуулж, хууль журам, ёс зүйг баримтлан, төрийн үйлчилгээг зорилтот бүлгийн өрх, иргэнд чанартай, шуурхай хүргэнэ.” эрхэм зорилгыг удирдлага болгон төрийн үйлчилгээг чирэгдэлгүй шуурхай үзүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг чанд сахих гэсэн зарчмыг баримтлан “Халамж хүртэгчээс - Баялаг бүтээгч” гэсэн алсын хараагаар зорилгоо хэрэгжүүлж байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Улсын төсвөөс санхүүждэг Халамжийн сангийн үйлчилгээнүүд 2022 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс Е-халамж цахим программд шилжсэнээр тус газрын мөнгөн хөрөнгийн дансаар дамжихгүй иргэнд шууд олгож байгаа тул санхүүгийн бүртгэлийг хийхгүй болсон. Иймд санхүүгийн тайлан нь 2022 оны 01 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон гүйлгээг тайлагнасан болно.

Хөвсгөл аймгийн Халамжийн сан нь улсын төсвийн хөрөнгөөр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

1. Хоол тэжээлийн тусламж, дэмжлэг
2. Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт
3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээ

Тайлант хугацаанд дээрх тэтгэмж үйлчилгээтэй холбоотой хууль эрх зүйд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Хөвсгөл аймгийн ХХҮГ нь дотоод хяналт хариуцсан 2 ажилтантай ба Халамжийн сангийн үйл ажиллагаанд өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл, төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ.

*Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар*

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны А/174 тоот тушаалаар шинэчлэн баталж, мөрдсөн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийг 0 дүнтэй тайлагнасан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
<b>Нийт хөрөнгө</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/			
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

Дээрх хүснэгтээс харахад, Хөвсгөл аймгийн Халамжийн сан нь бараа материал, үндсэн хөрөнгө зээмшдээгүй бөгөөд тайланд онд авлага, өглөг үүсгэлгүй ажилласан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,025,112.0 мянга төгрөг, нийт зарлагыг 3,025,112.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн саналыг Сангийн яам хянаж ХХҮЕГ-аас 2022 оны төсвийг 3,025,112.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг тодотгоогүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,025,112.0 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тооцсон байна. Улсын төсвөөс санхүүждэг Халамжийн сангийн үйлчилгээнүүд 2022 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс Е-халамж цахим программд шилжсэнээр тус газрын мөнгөн хөрөнгийн дансаар дамжихгүй иргэнд шууд олгож байгаа тул санхүүгийн бүртгэлийг хийхгүй болсон тул батлагдсан төсвийг 183,944.0 мянган төгрөг болгон бууруулсан.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 183,944.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 1,318.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 182,625.3 мянган төгрөг буюу 99.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 1,318.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80711	Хүнс тэжээлийн дэмжлэг	64,944.0	64,944.0	-	100
80714	Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээ	100,100.0	98,753.0	1,247.0	98.7
80713	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт	19,000.0	18,928.3	71.7	99.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Нэмэлт төсвийн дансгүй.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв/ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Халамжийн сангийн /Улсын төсөв/ 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 58 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 3,678.9 мянган төгрөг гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 183,944.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 3,678.9 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Хөвсгөл аймгийн Халамжийн сан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой ажил гүйлгээ гаргаагүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчил гараагүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар алдаа зөрчил гараагүй

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн НББББ-тэй холбоотой өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1			1	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>			<b>1</b>	<b>100</b>

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тайлангийн дараа өмнөх оны халамжийн мөнгийг олгосон эсэхийг хянаж, санхүүгийн тайлан тодруулгад туссан эсэхийг анхаарах

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулсан алдаа байхгүй

#### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт өгөөгүй

#### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй

#### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж хүргүүлээгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### БАТАЛГААЖУУЛАЛТ:

ХОЁР ДАХЬ ШАТНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ХИЙСЭН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ ХИЙСЭН:  
АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТЫН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

С.ГАНСҮХ ОГНОО: